



ДУНДГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 04

Сангийндалай

┌ Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Хороодын бүрэлдэхүүн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.3 дахь заалт, 45 дугаар зүйлийн 45.1, 45.2, 45.3 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Анхдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тасралтгүй, байнгын үйл ажиллагааг хангах, хуралдаанд хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал дүгнэлт гаргах, хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүрэг бүхий дараах 6 хороог байгуулсугай.

- 1.1. Нутгийн удирдлагын хөгжлийн хороо
- 1.2. Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хороо
- 1.3. Нийгэм, цахим бодлогын хөгжлийн хороо
- 1.4. Хот суурин, дэд бүтцийн хөгжлийн хороо
- 1.5. Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хороо
- 1.6. Ёс зүйн хороо

2. Хороодыг 7 төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй байхаар тогтоосугай.

3. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бодлогын хороодын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

4. Батлагдсан журмыг мөрдлөг болгон хороодын үйл ажиллагааг зохион байгуулан ажлаа хагас бүтэн жилээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг хороодын дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.СҮХБАЯР